



Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр
“Монголиан Файнэншл Партнерс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
МФП-26/10-02 тоот хурлын тогтоолын Хоёрдугаар хавсралт

Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр /цаашид, “хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь “Монголиан Файнэншл Партнерс ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрэхийг зорино.
 - 1.2.1. компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээлэлээр цаг хугацаанд нь хангах;
 - 1.2.2. хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;
 - 1.2.3. компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангах;
 - 1.2.4. компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулах;
- 1.3. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын хууль тогтоомж, компанийн бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааварт нийцсэн байна.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 2.1 Компани нь хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр хүргэнэ.
 - 2.1.1 Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
 - 2.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
 - 2.1.3 Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл;
 - 2.1.4 Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;
 - 2.1.5 Хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;
 - 2.1.6 Компанийн шаардлагатай бусад мэдээлэл.
- 2.2 Хөтөлбөрийн 2.1-д заасан мэдээллийг хүргэхдээ Компанийн Тогтвортой хөгжлийн бодлогод тусгасан хүний эрхийн мэдрэмжтэй, тэгш хүртээмжтэй зарчмыг баримтална.
- 2.3 Компани нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.
 - 2.3.1 хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;
 - 2.3.2 хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;
 - 2.3.3 санал бодлыг хүлээн авах;
 - 2.3.4 мэдээлэл хүргэх, солилцох;
 - 2.3.5 шаардлагатай тохиолдолд бусад хэлбэрээр хүргэнэ.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ

- 3.1 Хөрөнгө оруулагч нь өөрийн санал, хүсэлтээ Гүйцэтгэх удирдлагад өөрийн биеэр эсвэл албан мэйлээр, цаасаар, цахимаар өгч болно.
- 3.2 Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэхдээ мэдээллийн нууцлалыг хангаж, хүний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтална.
- 3.3 Хөрөнгө оруулагчийн ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авсан тэр даруй Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /цаашид, "ТУЗНБД" гэх/-д хүлээлгэн өгнө.
- 3.4 ТУЗНБД нь санал, хүсэлт, гомдолтой танилцаж, бүртгэн ТУЗ-ийн зохих хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 3.5 ТУЗ-ийн хороо нь санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ хөрөнгө оруулагчийн хуульд заасан эрхийг хүндэтгэж, мэргэжлийн ёс зүйтэй байж холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм журмыг баримтлан цаг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэж, хэрэгжилтийг хангахыг ТУЗНБД-д даалгана.
- 3.6 ТУЗНБД нь шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар Гүйцэтгэх удирдлагад чиглэлийг өгч, тус чиг үүргийн хэрэгжилтийг Гүйцэтгэх удирдлагаас ТУЗНБД-д тайлагнана.
- 3.7 Хөрөнгө оруулагчийн гаргасан санал хүсэлт, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор хариуг цаасаар, цахимаар хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд Компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тус хугацааг ажлын 5 хүртэлх хоногоор сунгаж болно.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 4.1 Компанийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.
- 4.2 Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтэд компанийн ТУЗ-өөс хяналт тавина.
- 4.3 Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор компанийн ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.
- 4.4 ТУЗНБД нь хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайлан мэдээллийг компанийн ТУЗ-ийн хуралд тайлагнана.

---oOo---